



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2007 оны 11 сарын 29 өдөр
хот

Дугаар 176

Улаанбаатар

“Даатгалын үйл ажиллагаа эрхлэх этгээдтэй
холбогдох мэдээллийг хэвлэн нийтлэх журам”
батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Даатгалын тухай хуулийн 14.2.21 дэх заалтуудыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос **ТОГТООХ нь:**

1. “Даатгалын үйл ажиллагаа эрхлэх этгээдтэй холбогдох мэдээллийг хэвлэн нийтлэх журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү журмын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/, нийтэд сурталчлахыг Тамгын газар /Ж.Жадамбаа/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

**ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЭТГЭЭДТЭЙ ХОЛБОГДОХ МЭДЭЭЛЛИЙГ
ХЭВЛЭН НИЙТЛЭХ ЖУРАМ**

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэ журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хорооноос (цаашид Хороо гэнэ) даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчдод даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон, түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон тухай олон нийтэд хэвлэн нийтлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**Хоёр. Хорооноос даатгалын болон даатгалын мэргэжлийн
оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл
авсан этгээдийн талаар нийтэд мэдээлэх**

2.1. Хороо нь Даатгалын тухай хуулийн 20.9, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 11.7-д тус тус заасны дагуу даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авсан этгээдийн талаар бүртгэл хөтөлж, түүнд гарсан өөрчлөлтийн тухай Хорооны тогтоол гарсан өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор нийтэд мэдээлнэ.

**Гурав. Хорооноос даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан этгээдийн эрхийг түр түдгэлзүүлсэн
болон цуцласан талаар нийтэд мэдээлэх**

3.1. Хороо нь Даатгалын тухай хуулийн 71.3, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 38.8, 39.5-д тус тус заасны дагуу даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан этгээдийн эрхийг нь түр хугацаагаар түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон талаар Хорооны тогтоол гарсан өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор нийтэд мэдээлнэ.

**Дөрөв. Хорооноос даатгагчийн болон даатгалын мэргэжлийн оролцогчийн
санхүүгийн тайланг баталгаажуулах эрх авсан аудитор болон актуарчийн
эрх авсан этгээдийн талаар нийтэд мэдээлэх**

4.1. Хороо нь Даатгалын тухай хуулийн 33.3-д заасны дагуу даатгалын үйл ажиллагаа эрхлэх этгээдийн санхүүгийн тайланг баталгаажуулах эрх бүхий аудиторын бүртгэл хийж, түүнд гарсан өөрчлөлтийн талаар Хорооны тогтоол гарсан өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор нийтэд мэдээлнэ.

4.2. Хороо нь Даатгалын тухай хуулийн 39.3-д заасны дагуу актуарчийн эрх авсан этгээдийн бүртгэл хийж, түүнд гарсан өөрчлөлтийн талаар Хорооны тогтоол гарсан өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор нийтэд мэдээлнэ.

Тав. Нийтэд мэдээлэх мэдээлэлд тусгах зүйл

5.1. Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан этгээдийн талаар нийтэд мэдээлэхдээ дараах зүйлсийг тусгана. Үүнд:

- 5.1.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр;
- 5.1.2. Эрхлэх даатгалын ангилал, төрөл, хэлбэр;
- 5.1.3. Тусгай зөвшөөрөл олгосон огноо, тогтоолын дугаар.

5.2. Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрхийг түр хугацаагаар түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон тухай нийтэд мэдээлэхдээ дараах зүйлсийг тусгана. Үүнд:

- 5.2.1. Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр;
- 5.2.2. Даатгалын үйл ажиллагаа эрхлэх даатгалын ангилал, төрөл, хэлбэр;
- 5.2.3. Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон хэлбэр, төрөл;
- 5.2.4. Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон огноо;
- 5.2.5. Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон хугацаа.

5.3. Даатгагчийн болон даатгалын мэргэжлийн оролцогчийн санхүүгийн тайланг баталгаажуулах эрх авсан аудиторовн талаар нийтэд мэдээлэхдээ дараах зүйлсийг тусгана. Үүнд:

- 5.3.1 Аудит хийх эрх эзэмшигч аудиторовн нэр;
- 5.3.2 Аудит хийх эрх олгосон огноо, тогтоолын дугаар;
- 5.3.3 Аудит хийх эрхийн хугацаа;
- 5.3.4 Аудит хийх эрхийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон огноо, тогтоолын дугаар.

5.4. Актуарчийн үйл ажиллагааны эрх авсан актуарчийн талаар нийтэд мэдээлэхдээ дараах зүйлсийг тусгана. Үүнд:

- 5.4.1. Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх эзэмшигч актуарчийн овог нэр;
- 5.4.2. Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгосон огноо, тогтоолын дугаар;
- 5.4.3. Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийн хугацаа;
- 5.4.4. Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон огноо, тогтоолын дугаар.

Зургаа.Бусад

6.1. Хорооноос даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон талаар нийтэд мэдээлснийхээ төлөө тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өмнө хариуцлага хүлээхгүй.

6.2. Даатгалын үйл ажиллагаа эрхлэх этгээдтэй холбогдох мэдээллийг Хорооны Даатгалын газар хариуцаж, Хорооны мэдээллийн самбар, вэб хуудас, сонин, хэвлэлээр дамжуулан нийтэд хүргэнэ.

--ooOoo--